



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/02

Хөхбүрд

2023 оны цэргийн бүртгэл явуулах тухай

“Цэргийн албаны тухай хууль”-ийн 34 дүгээр зүйлийн 34.1, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, Батлан хамгаалахын сайдын “Цэргийн бүртгэл явуулах журам батлах тухай” 2017 оны А/331 дүгээр тушаалаар батлагдсан журам, аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн А/738 дугаар захирамжыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны цэргийн тоо бүртгэлийг 2021 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 01 дүгээр сарын 11-ний өдрүүдэд явуулсугай.

2. Цэргийн бүртгэлийн ажлын хэсгийн доорх бүрэлдэхүүнийг томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Жавзансүрэн (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Т.Цэцэгсайхан (Мандалхайрхан 1 дүгээр багийн Засаг дарга)

С.Энх-Амгалан (Уранхайрхан 2 дугаар багийн Засаг дарга)

М.Сэр-Од (Асгамба 3 дугаар багийн Засаг дарга)

Б.Дагдансүрэн (Мэргэн 4 дүгээр багийн Засаг дарга)

Ө.Ариунзаяа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Ц.Бямбасүрэн (Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Г.Ууганжаргал (Татвар хураагч)

н.Дашбалбар (Хэсгийн төлөөлөгч)

3. Сумын хэмжээнд цэргийн насны 18-60 эрэгтэйчүүдийг бүрэн хамруулахыг багийн Засаг дарга нарт даалгах нь:

а. Цэргийн бүртгэлийг зохион байгуулахтай холбогдуулан иргэд, цэргийн үүрэгтнүүдэд Монгол Улсын Цэргийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль, 6/22011/7

эрх зүйн баримт бичгүүдийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг шуурхай зохион байгуулах,

б.Монгол Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журмын дагуу цэргийн бүртгэлээр ажиллах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нууц хадгалалт, хамгаалалтыг чанд сахиж, Төрийн болон албаны нууцыг задруулахгүй байх баталгааг хүн нэг бүрээр гаргуулж авах,

в.2005 онд төрсөн 18 нас хүрсэн иргэнийг харьяа сумын бүртгэл явагдах байранд өөрийн биеэр ирж цэргийн бүртгэлд хамруулах,

г.E-Mongolia цахим бүртгэл 2023 оны 01 дүгээр сарын 09-11-нийг хүртэл явагдах тул бүртгэлд хамрагдаж, бүртгүүлсэн тухайгаа багийн Засаг даргадаа мэдэгдэх,

д.Албан байгууллагадаа ажиллаж байгаа 18-60 насны эрэгтэй ажилчин, албан хаагчдын нэрийн бүртгэлээр бүртгэлийн ажлыг явуулж, мэдээ, тайланг 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр Цэргийн штабт ирүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн)-д даалгасугай.

4.Цэрэг тоо бүртгэлийн зардалд шаардагдах хөрөнгийг сумын Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Санхүүгийн албаны дарга (Д.Эрдэнэбулган)-д зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ХАТАНБААТАР